# УЛААНБААТАР ХОТЫН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НУТАГ ДАХЬ “АХУЙ МАНДАЛ ДАХИВАР ҮЙЛДВЭР”-ИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**РД: 5537266**

Төсөл хэрэгжүүлэгч: **“АЛТАН ОРШИХУЙ ГРУПП” ХХК**

**УЛААНБААТАР 2025 он**

## ГАРЧИГ


ОРШИЛ

1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА ........ 1
1.1 Ерөнхий мэдээлэл ........ 1
1.1.1 Төсөл хэрэгжүүлэгч ........ 1
1.1.2 Төслийн зорилго ........ 1
1.1.3 Төслийн эзэмшлийн газар, үйлдвэрийн байршил ........ 1
1.1.4 Газар ашиглалт ........ 2
1.1.5 Үйлдвэрийн хүчин чадал ........ 3
1.2 Төслийн талбай орчмын бүс нутгийн тодорхойлолт ........ 3
1.2.1 Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт ........ 3
1.2.2 Түүхий эдийн шинж чанар, үйлдвэрийн технологи ........ 5
1.2.3 Нийгэм-эдийн засгийн төлөв байдлын тодорхойлолт ........ 7
1.3 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт ........ 8
1.3.1 Байгаль орчны нөлөөллийн тодорхойлолт ........ 8
1.3.2 Үйлдвэрийн нийгмийн ач холбогдол ........ 9
2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 10
2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цар хүрээ ........ 10
2.1.1 Менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт ........ 10
2.1.2 БОМТ-ний хамрах хүрээ ........ 10
2.1.3 БОМТ-ний нийт зардал, түүний бүтэц ........ 11
2.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ........ 11
2.3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө ........ 13
2.4 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ ........ 15
2.5 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө ........ 15
2.5.1 Аваар осол гарсан онцгой байдлын үед авах арга хэмжээ ........ 15
2.5.2 Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ ........ 15
2.5.3 Хүний эрүүл мэндийг хамгаалах ........ 16
2.5.4 Хүхрийн хүчил, аюултай хаягдлын мэдээллийн сан, бүртгэл ........ 18
2.5.5 Үйлдвэр танилцуулах аялалын аюулгүй байдал ........ 18
2.6 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө ........ 20
2.7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ........ 22
2.8 2023 оны БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ........ 24
2.9 2023 оны БОМТ-ний хэрэгжилтийг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө ........ 25
ДҮГНЭЛТ
АШИГЛАСАН МАТЕРИАЛ
ХАВСРАЛТ

# ОРШИЛ

Улаанбаатар хотын Багахангай дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт хаягдал шатах тослох материал дахин боловсруулах үйлдвэрлэл эрхэлж байгаа “Алтан оршихуй групп” ХХК нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах 3.0 га талбайг 15 жилийн хугацаатай эзэмшиж байна. Эзэмшил талбайн 54.0 хувьд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж угсрах ,хатуу хучилттай зам талбай тавих зэргээр идэвхтэй ашиглаж байгаа.

Үйлдвэрийн хувьд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг байгаль орчны мэргэжлийн байгууллага болох “Төгрөг баян хангай” ХХК-аар хийлгэж байгаль орчны менесентийн 5 жилийн төлөвлөгөөг батлуулж байсан. “Аюултай хог хаягдал дахин боловсруулах” тусгай зөвшөөрлийг гаргуулан авч 2025 оноос үйл ажиллагаа нь урсгал засварын түвшинд байгаа бөгөөд одоо 2025 оны БОМТ боловсруулаад байна.

Үйлдвэрийн 2025 онд хэрэгжүүлэх БОМТ-г боловсруулахад байгаль орчны судалгаа, үнэлгээний мэргэжлийн байгууллага болох “ТӨГРӨГ БАЯН ХАНГАЙ” ХХК-аас мэргэжлийн зөвлөгөө авсан бөгөөд төлөвлөгөөг БОАЖЯ-наас 2019-10-29-ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд төлөвлөлтийг тус журмын 3 дугаар хавсралтын “Г”-д заасан агуулгаар боловсруулсан болно.

БОМТ-г нийт 2 бүлэг, 11 дэд бүлэгт багтаан 17 хүснэгт, 9 зураг, схем, график, загварчилал болон тооцооллыг нотлох 12 хавсралтаар баримтжуулсан.

**“АЛТАН ОРШИХУЙ ГРУПП” ХХК**

# 1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Ерөнхий мэдээлэл

### *1.1.1 Төсөл хэрэгжүүлэгч*

<table>
<tr><td colspan="3">Нэг. Ерөнхий мэдээлэл</td></tr>
<tr><td>1.1</td><td>Төсөл хэрэгжүүлэгч ийн мэдээлэл</td><td>"Алтан Оршихуй Групп" ХХК<br>РД: 5537266, ХХД: 9011321042</td></tr>
<tr><td>1.2</td><td>Төсөл хэрэгжүүлэгч ийн хаяг</td><td>Улаанбаатар хот, Багахангай дүүрэг, 2-р хороо, Хангайн 7-6 тоот, Утас: 70005065, 99110513</td></tr>
<tr><td>1.3</td><td>Батлагдсан ерөнхий үнэлгээний дүгнэлт</td><td>Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2024 оны 04 сарын 08-ны өдрийн 12/1558 тоот ерөнхий үнэлгээний батлагдсан дүгнэлт</td></tr>
<tr><td>1.4</td><td>Хог тээвэрлэлийн гэрээ</td><td>"Багахангай тохижилт" ОНӨААТҮГ-тэй 2024 оны 01 сарын 10-ны өдөр байгуулсан хог тээврийн гэрээ</td></tr>
<tr><td colspan="3">Хоёр. Төслийн талаарх мэдээлэл</td></tr>
<tr><td>2.1</td><td>Төслийн нэр</td><td>"Ахуй мандал" дахиварын үйлдвэр</td></tr>
<tr><td>2.2</td><td>Төслийн байршил</td><td>Тус үйлдвэр Улаанбаатар хотоос 85 км зайд Улаанбаатар хотын Багахангай дүүргийн 1-р хороо, Үйлдвэрлэлийн хэсэг гудамж, /12340/, 47 тоот хаалганд оршдог бөгөөд талбайн хэмжээ 30000 м2 байна. Улаанбаатар Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай авто зам болон төмөр зам дайран өнгөрөх дэд бүтцийн таатай байршилтай.


Газрын байршил нь орон сууц, олон нийтийн байгууламж бүхий хэсгээс 5 км-ийн зайд байрладаг нь 2017 оны 5 дугаар сарын 12-нд батлагдсан "Хог хаягдлын тухай хууль" –ийн 25.1 дэх шаардлага болон "Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага" MNS 5105 : 2001 стандартын шаардлагыг хангаж байна.</td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td></td><td>
</td></tr>
<tr><td>2.3</td><td>Төслийн ерөнхий танилцуулга</td><td>Ерөнхий мэдээлэл:<br><br>Тус компани нь хаягдал тос боловсруулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгыг 2016 оноос эхлэн тавьж ажиллаж байна.<br>- “Алтан Оршихуй Групп” ХХК нь дээр дурдсан хэрэгцээ шаардлага дээр үндэслэн байгаль орчноо хамгаалах, импортыг орлох эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн ажлыг 2012 оноос эхлүүлж одоогийн байдлаар сард тогтмол 70-75 тонн аюултай хог хаягдал болох техникийн хаягдал тосыг дахин боловсруулж 40-45 тонн евро-4 стандартын шаардлага хангасан Дизель түлш үйлдвэрлэж байна.<br>- “Алтан оршихуй групп” ХХК- ийн Ахуй мандал дахиварын үйлдвэр нь 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлж эхэлсэн.<br>- Өөрийн үйлдвэрлэсэн “Монгол Эко” дизель түлшийг Баян суманд байрлах өөрийн “Баянмандал” ШТС-ээр дамжуулан борлуулдаг. Мөн гэрээт ШТС-үүдээр дамжуулан борлуулдаг.<br>- Түүхий эд нийлүүлэгч байгууллагууд:<br>- Паберлик сервис ХХК, Баян-айраг ХХК, Клейн энержи ази ХХК, СЭБОЦЭ ХХК, ФЛСмидт Монголиа ХХК, Арева майнс ХХК, МАК ХХК, Илт Гоулд ХХК, Олборлолт ХХК, Ханбогд Вейст Менежмент Центр ХХК зэрэг 10 байгууллага байна. /Хавсралтаар хүчинтэй гэрээнүүдийг хавсаргав/<br>“Монгол эко дизель түлш” худалдан авдаг байгууллага:<br>- “Наран хүрээтэй уул” ХХК-нд нийлүүлдэг. /Хавсралтаар хүчинтэй гэрээг хавсаргав/<br>- Төслийн талбайд 845 м$^2$ талбайтай 6 метрийн өндөртэй үйлдвэрийн барилга байдаг бөгөөд 62.55м*13.52м хэмжээтэй дулааны цех, боловсруулах цех, оффис, лаборатори, 7 м$^2$ химийн агуулах зэргээс бүрдэнэ. Мөн төслийн талбайд цахилгаан дэд станц, дизель генератор, харуулын байр, 14ш нөөцийн сав зэрэг обьектууд байрлана.<br>Өнөөдрийг хүртэл:</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | - *Тус үйлдвэрийн бүтээгдэхүүн "Монгол эко" дизель түлш нь УБД0000302 дугаар бүхий чанарын тохирлын гэрчилгээ авсан буюу евро-4 стандартын шаардлага хангасан* /Агуулагдах хүхрийн хэмжээгээрээ тодорхойлогддог- тус үйлдвэрийн дизель түлш нь стандартаас заасан хэмжээнээс бага хүхрийн агууламжтай тул байгаль орчинд хор багатай/<br>- *Өнөөдрийг хүртэл тус үйлдвэр нийт 5 000 000 литр гаруй тонн хөдөлгүүрийн ашигласан тосыг дахин боловсруулж байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулсан байна.*<br>- *Нийт нөөцийн 50 тн-ийн 14 ширхэг паспорттай савтай. Үүнээс газар доор байрлалтай 5 сав, ил байрлалтай 9 сав байна.*<br>- *Мөн шинээр үйлдвэрийн өргөтгөл хийж нөөцийн 2ш ёмкоос нэмэх, ногоон байгууламж, үйлдвэрийн байр, технологийн хувьд шинэчлэлт хийж жилд 12500тн хаягдал дахин боловсруулж дизель түлш үйлдвэрлэх, авто машины зогсоол, дотоод автомашины зам тавих, гэрэлтүүлэг хийх, химийн бодисын агуулахаа өргөтгөх зэрэг өргөтгөл хийгдэнэ.*<br>**Тус үйлдвэрийн амжилтаас***:*<br>- *Нийгмийн хариуцлагатай байгууллага өргөмжлөл цом,*<br>- *Улаанбаатар хотын 374 жилийн ойн нэрэмжит "Бүтээн байгуулалтын дээд шагнал"*<br>- *Олон улсын "Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох чадавхийг бэхжүүлэх, олон нийтийн оролцоог дэмжих сургалт-семинар", 2015 он*<br>- *Тус группын ерөнхийлөгч нь Байгаль орчны тэргүүний ажилтан,*<br>- *Аж үйлдвэрийн тэргүүний ажилтан гэх мэт олон шагнал, өргөмжлөл цом авсан байна* |
| 2.4 | Төслийн зорилго | Байгальд үл шингэх хог хаягдлыг дахин боловсруулж, байгаль орчныг хамгаалах бодлого хөтөлбөрүүдийг дэмжсэн үйл ажиллагаа явуулах, |

<table>
<tr>
<td>2.5</td>
<td>Төслийн ерөнхий төлөвлөгөө</td>
<td>



Тус үйлдвэр нь хаягдал тос болон бүтээгдэхүүн хадгалах, нэрэх цех гэсэн үйлдвэрлэлийн үндсэн хэсэгтэй.<br>
Үйлдвэр нь жилд 9000 тонн Дизель түлш болон 2500тн мазут бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал бүхий тос хадгалах болон нэрэх хэсэг гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.
</td>
</tr>
<tr>
<td>2.5</td>
<td>Төслийн хүчин чадал</td>
<td>
<ul>
<li>Одоогийн байдлаар тус үйлдвэр нь хоногт 26тн дизель түлш, 8 тонн мазут үйлдвэрлэх хүчин чадалтай байна.</li>
<li>Ахуй мандал шинэ төсөл хэрэгжсэнээр өдөрт 40тн, Жилд 12500 тонн хаягдал тосыг боловсруулна.</li>
<li>Төсөлд одоогоор нийт 10 хүн ажиллаж байна. Цаашид 66 хүн ажиллана.</li>
<li>Жилд 312 хоног 4 ээлжээр ажиллана.</li>
</ul>
<table>
<tr><th>№</th><th>Бүтээгдэхүүн</th><th>Төрөл стандарт</th><th>Хэмжих нэгж</th><th>Үйлдвэрлэл, жилд</th></tr>
<tr><td>1</td><td>Хаягдал тос</td><td>Байгууллагын стандарт</td><td>тн</td><td>12500</td></tr>
<tr><td>2</td><td>Дизель түлш</td><td>MNS 6861:2020</td><td>тн</td><td>8125</td></tr>
<tr><td>3</td><td>Мазут</td><td>MNS 3828 : 2008</td><td>тн</td><td>2500</td></tr>
</table>
</td>
</tr>
</table>

<table>
<tr>
<td>2.6</td>
<td>Төслийн ерөнхий технологи</td>
<td>
Хаягдал тос боловсруулах технологийн ерөнхий бүдүүвч




Технологийн тоноглолын ерөнхий байдал




Хаягдал тос боловсруулах үйлдвэрийн технологийн бүдүүвч
</td>
</tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | <br> |
| 2.7 | Төслийн хог хаягдал | **Хатуу хог хаягдал:**<br>Ахуйн хатуу хог хаягдлын тооцоогоор хоногт 56.76 кг, жилд 17.7 тн орчим хаягдал гарах бөгөөд харъяа дүүргийнхээ холбогдох /ТҮК/-тэй байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэх, ачуулах асуудлыг цаг тухайд нь тогтмол шийдвэрлэдэг байна. Үйлдвэрлэлийн технологийн хувьд эцсийн шатанд хаягдал мазут шаар үлддэг ба түүнийг дахин шатаана. Бусад хог хаягдлыг “Цэцүүх” ХХК, “Элемент” ХХК зэрэг компаниудад нийлүүлнэ. Шаталтаас үүссэн үнсэн хаягдал болон үнс баригчаас гарсан 2 төрлийн үнсэн хаягдлыг тус тусад төмөр таглаатай саванд хадгалах шаардлагатай. Шаталтаас үүссэн үнсэн хаягдлыг дүүргийн хот тохижуулах газартай хийсэн гэрээний дагуу нийлүүлж зайлуулна.<br>Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгана.<br>- Дахин ашиглах боломжтой хог хаягдал: Төрөл бүрийн цаас, картон, цаас, хуванцар сав, сав баглаа боодол, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут гэх мэт<br>- Бусад хог хаягдал: Үнс, түргэн муудах хоол хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдлууд<br>- Ахуйн аюултай хог хаягдал: Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал /ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн, дугуй/ унтраалга-залгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, электрон барааны хаягдал /компьютер, телевизор% гар утас/ цэвэрлэгээний бодис, зарим тусгай батерей зэргүүд хамаарна.<br>*Доорхи зургийн дагуу хог хаяглдыг ялгаж хаях шаардлагатай* |

| | | |
|---|---|---|
| | | <br>**Шингэн хог хаягдал:**<br>Ахуйн шингэн хог хаягдлын тооцоогоор хоногт үйлдвэрийн нэг ажилтны усны нормын дагуу өдөрт 80 литр бөгөөд нийт 66 ажилтантай гэж үзвэл хоногт 5.28 м$^3$, жилд 312 хоног ажиллах хугацаанд нийт хэрэглэх усны хэмжээ 1647.36 м$^3$/жил, үүнээс 70%-ийг хаягдал ус гэж үзвэл 1153.152 м$^3$/жил болно.<br>Төслөөс гарсан ахуйн бохир усыг зөөврийн аргаар 5 тонны багтаамж даац бүхий зориулалтын машинаар соруулна. "МҮТТ" ХХК-ийн дотоодод үйлдвэрлэж байгаа бохир ус агуулах 30м3 ын бохирын танк (бохироо соруулах худагт таг, агааржуулалтын хоолойтой сэт) –ыг суурилалтын ажлыг мэргэжлийн компаниар хийлгүүлж, газрын хэвлийд хөлдөлтийн түвшингээс доор 4-5 метрт байгуулж ашигладаг. Бохир соруулах гэрээтэй.<br> <br>**Хийн хаягдал:**<br>Үйлдвэр нь бүрэн хүчин чадлаараа ажиллах үед хоногт 3 кг мод, 3 тн мазут, 10 м$^3$ хий шатаах тооцоо гарч байна. Эдгээрээс жилдээ ялгарах хүлэмжийн хийн тооцоогоор хаягдал хийн агууламж 450.1 м3/цаг, нэг жилд 9948.5кг/жил хий ялгаруулах ба үүнээс мод 2118.5кг/жил, мазут 4620 кг/жил, хий 7222 кг/жил болно.[1] Жилд ялгаруулах хүлэмжийн хийг багасгах зорилгоор үйлдвэрийн орчинд 628 мод тарихаар төлөвлөж өгсөн байна. Нэг модны хүлэмжийн хийг шингээх чадвар (21 кг/жил) байна. |
| 2.7 | Ариун цэврийн байгууламж | Үйлдвэрийн байран дотор төвлөрсөн ариун цэврийн байгууламжтай бөгөөд байгаль орчин, ариун цэврийн цаасыг зөв зохистой ашиглах, хувийн ариун цэвэр сахих соёлын тухай санамжуудыг байрлуулж ба экологийн боловсролын булан бий болгосон. |

[1] ТЭЗҮ, 118-р хуу

| | | |
|---|---|---|
| | |  |
| 2.8 | Усан хангамж | Үйлдвэрийн газрын цэвэр усны хангамжийг нийтийн гүний худгаас хангана. Үйлдвэрийн байрнаас 1.5 км зайтай байрладаг бөгөөд эрүүл ахуйн бүсийн шаардлага хангаж байна.<br>Төслийн үйл ажиллагааны эхэнд дулаан, унд ахуйн болон ахуйн хаягдал бохир усыг доор тусгасанаар шийдэх<br>Төсөл хэрэгжүүлэх компани нь Усны тухай хуулийн 28.6 , 28.11 дэх заалт, 29 дүгээр зүйлд заасны дагуу ус ашиглах зөвшөөрөл, эрхийн бичиг авч, ус ашиглах гэрээ байгуулан ажилладаг. |
| 2.9 | Цахилгаан хангамж |  <br>Цахилгаан хэрэглээгээ нэгдсэн сүлжээ буюу "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ХХК-ний хүчдэлийн шугамаас трансформатор байгуулсны үндсэн дээр эрчим хүчний асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. Зориулалт бүхий шонгуудыг газарт суулган бэхлэж, цахилгааны утас татах, дэд станц байрлуулах, цахилгааны шугамны гадна ба дотор талын холболтын ажлыг тусгайлсан зураг гаргаж, мэргэжлийн хүмүүсээр өндөр түвшинд гүйцэтгүүлсэн. |
| 2.1 | Дулаан хангамж | Тус байгууламж нь халаалтанд эрчим хүчний хэмнэлттэй халаалтын систем буюу усан бойлер хэрэглэдэг.<br>Мөн үйлдвэрийн процесс нь нүүрсний галлагаа шаарддаг тул дулаан хангамжийн хувьд хангалттай дулаахан байдаг. |

### *1.1.2 Нийгэм-эдийн засгийн төлөв байдлын тодорхойлолт*

"Алтан оршихуй групп" ХХК-ийн төсөл нь Улаанбаатар хотын Багахангай дүүргийн 1-р хорооны Үйлдвэрлэлийн хэсэг гудамж /12340/-ны 47 тоотод байрладаг.

**Багахангай дүүргийн түүх, уламжлал**

**Дүүргийн үүсэл, хөгжлийн түүх.** Багахангай дүүрэг нь анх 1989 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн БНМАУ, Эдийн засгийн гадаад харилцаа, хангамжийн яамны сайдын 149 дүгээр тушаалаар, Зөвлөлтийн цэргийн ангийн Мааньт хотхоны барилга байгууламжийг хүлээн авч, бараа материал нүүлгэх, хадгалах, хэрэглэгчдэд нийлүүлэх ажлыг зохион байгуулах ашиглалтын захиргааг байгуулж, үүнээс 5 хоногийн дараа, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1989 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 98дугаар тогтоолоор, БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газрын хооронд тохиролцсоны дагуу эх орондоо буцаж байгаа зөвлөлтийн цэргийн анги, нэгтгэлийн хотхонуудыг хүлээн авч ашиглахтай холбогдуулан, Төв аймгийн Мааньт дахь хотхонд тухайн үеийн Эдийн засгийн гадаад харилцаа, хангамжийн яамны харьяа Улаанбаатар хот дахь материал-техникийн хангамжийн зарим баазууд болох Шатахуун, ачаа тээвэр, материал-техник хангамжийн авто баазыг шилжүүлэн байршуулснаар дүүрэг үүсэх эхлэл тавигдсан байна. Үүний дараа БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1989 оны 08 сарын 08-ний өдрийн 126 дугаар тогтоолоор Төв аймгийн Өндөртолгойд шинээр байгуулагдсан үйлдвэрлэлийн газар, соёл боловсрол, үйлчилгээний байгууллагуудыг харьяалсан Төв аймгийн Багахангай хороо байгуулсан байна. АИХ-ын Тэргүүлэгчдийн 1990 оны 170 дугаар зарлигаар Төв аймгийн Багахангай хороог буцаж, нийслэлийн харьяанд оруулсан бөгөөд 1992 оны шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалтын хүрээнд УИХ-ын 18 дугаар тогтоолоор хотын раойн, хороодыг татан буулгаж шинээр Багахангай дүүрэг байгуулснаар өнөөгийн хотын нэг дүүрэг болж өргөжсөн.

Тус дүүрэг Улаанбаатар хоттой 107 км төмөр замаар, 90 км хатуу хучилттай хар замаар холбогдсон бөгөөд Улаанбаатар-Замын-Үүд, Улаанбаатар-Багануур чиглэлийн төмөр замын зангилаа дээр болон Улаанбаатар-Замын-Үүдийн босоо тэнхлэгийн хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг хэсэг дээр оршдог.

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 54-р тогтоолоор нийслэлийн Багахангай дүүрэгт "Үйлдвэрлэл технилогийн парк" байгуулах зориулалт, хэлбэр чиглэлийг тодорхойлж өгсөн нь тус дүүргийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон томоохон арга хэмжээ боллоо.

**АЛСЫН ХАРАА:** Дүүргийн хэмжээнд хууль, тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулах, иргэдэд соёлч боловсон үйлчлэх, төрийн байгууллагын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг боловсролыг дээшлүүлж, мэргэшсэн тогтвортой боловсон хүчнээр хангах, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх замаар нийслэлийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллагуудын манлайлагч байх.

**ЭРХЭМ ЗОРИЛГО:** "Төрийн захиргаа, иргэн, хувийн хэвшлийн түншлэлд түшиглэн, үнэн зөв, ил тод мэдээллийн эх сурвалж ашиглан, дүүргийн нийгэм эдийн засгийн хөгжлийн бодит нөхцөлд шинжилгээ хийж, иргэддээ үйлчилдэг, өндөр мэдлэг, ур чадвартай зарчимч мэргэшсэн, төрийн албан хаагчдыг үр дүнтэй, тогтвортой ажиллах орчин нөхцлийг бүрдүүлж, дүүргийн удирдлагад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд оршино".

\Дүүргийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн бодлогын зорилтууд 2030 он хүртэл




Багахангай дүүргийн газар нутаг, ашиглалт

**Дүүргийн газар нутгийн хэмжээ.** Багахангай дүүрэг нь 140.0 км² нутаг дэвсгэртэй далайн түвшнээс дээш 1614 метр өргөгдсөн. Нийслэлээс өмнө зүгт 90км зайд, баруун хойд талаараа Төв аймгийн Сэргэлэн сум, зүүн болон урд талаараа Баян сумтай хил залган оршдог.

Нийслэлийн алслагдсан дүүргүүдийн нэг юм.




*Зураг 1. Багахангай дүүргийн газарзүйн байрлал*

Багахангай дүүрэг нь 140.0 км² нутаг дэвсгэртэй. 2022 оны байдлаар 1 м2 нутагт 0.03 хүн ноогдож байна. Засаг захиргааны хувьд нийт 2 хороотой байна. Хороо нь засаг захиргааны хувьд Засаг дарга, зохион байгуулагч, нийгмийн ажилтан, олон нийтийн байцаагч, хэсгийн ахлагч, үйлчлэгч гэсэн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

**1-р хороо** нь Нийслэлийн Багахангай дүүргийн 1 дүгээр хороо нь Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу 1992 онд анх байгуулагдсан. Тус хороо нь 8.0 мянган га газар нутагтай зүүн хойд болон хойд талаараа Төв аймгийн Сэргэлэн сум, зүүн талаараа Багахангай дүүргийн 2 дугаар хороо, зүүн урд талаараа Төв аймгийн Баян сумтай хиллэн тал хээрийн бүсэд оршдог.

Тус хороонд 719 өрхийн 2503 хүн амтай. 2022 оны эцэст 16731 толгой мал тоологдсон.

Нутаг дэвсгэрийн 515.5 га буюу 4.3%-д хүн ам суурьшсанаас 2022 оны эцсээр хөдөлмөрийн насны хүн 1345 буюу 53.7%-ийг эзэлж байна. Хорооны хүн амын 168 иргэн хөдөлмөр эрхэлдэггүй, 49 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, оюутан 87, ахмад настан 310 байна.

**2-р хороо** нь Тус хороо нь 6000 га газар нутагтай бөгөөд Багахангай, Багануур, Замын-Үүд чиглэлийн төмөр замын дагуу баруун хойноос урагш 86 км сунаж тогтсон байрлалтай , дүүргийн төвтэй 7км хатуу хучилттай замаар холбогддог. Төвийн эрчим хүчний системд бүрэн холбогдсон .

Баруун талаараа тус дүүргийн 1-р хороотой зүүн талаар төв аймгийн баян сумтай хойд талаараа Төв аймгийн Сэргэлэн сумтай хиллэдэг Шугам замын Агуйт Хоолт Цагаанхяр 473-р км Чулуут 480 -р Хангайн Алсын худаг Мааньт Агуйт Булагтай зэрэг зөрлөгүүд Бор үзүүр Нуур Цайдам Замчин орон сууцны 11 Байрны иргэдийг хариуцан төрийн 6 төрийн бус 3 төмөр замын 10 хувийн хэвшлийн 10 Аж ахуй нэгж байгуулагатай хамтран 7 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаага явуулж байна

Тус хороо нь 538 өрхийн 1924 иргэнтэй байна.

**Хүн ам, хөдөлмөр эрхлэлт**

**Дүүргийн нийт хүн ам, өрхийн тоо.** Засаг захиргааны анхан шатны нэгж 2 хороотой. 2022 онд нийт хүн ам 4416 үүнээс 1-р хороо 2503, 2-р хороо 1913 хүн амтай бөгөөд 1230 өрхтэй юм.




*График 1.Багахангай дүүргийн хүн ам зүйн бүтэц*




*График 2. Багахангай дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбарууд /эзлэх хувиар/*

**Хүн амын хөдөлмөр эрхлэлт.** Багахангай дүүргийн хөдөлмөрийн насны хүн ам нийт хүн амын 48%-ийг эзэлж байсан бөгөөд хөдөлмөр эрхлэлт 4 салбарт голчлон зонхилж байна. Үүнд 2 хэсэг буюу 33 хувьд зонхилж буй мал аж ахуйн салбар, тус бүр 17 хувьд зонхилж буй нийгмийн ажил, төрийн захиргаа, батлан хамгаалах болон боловсролын салбарууд бүртгэгджээ.

*Хүснэгт 1. Багахангай, Багануур дүүргийн хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин*

| **Статистик үзүүлэлт** | **Аймаг** | **Хүйс** | **Насны бүлэг** | **2022** |
|---|---|---|---|---|
| Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, % | Багануур, Багахангай | Бүгд | Бүгд | 14.4 |
| Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, % | Багануур, Багахангай | Эрэгтэй | Бүгд | 17.3 |
| Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, % | Багануур, Багахангай | Эмэгтэй | Бүгд | 11 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Ажилгүйдлийн түвшин, % | Багануур, Багаханай | Бүгд | Бүгд | 11.2 |
| Ажилгүйдлийн түвшин, % | Багануур, Багаханай | Эрэгтэй | Бүгд | 15.1 |
| Ажилгүйдлийн түвшин, % | Багануур, Багаханай | Эмэгтэй | Бүгд | 6.3 |
| Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, % | Багануур, Багахангай | Бүгд | Бүгд | 11.2 |
| Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, % | Багануур, Багахангай | Эрэгтэй | Бүгд | 15.1 |
| Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, % | Багануур, Багахангай | Эмэгтэй | Бүгд | 6.3 |
| Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, % | Багануур, Багахангай | Бүгд | Бүгд | 14.3 |
| Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, % | Багануур, Багахангай | Эрэгтэй | Бүгд | 17.3 |
| Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн | Багануур, Багахангай | Эмэгтэй | Бүгд | 10.6 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| түвшин, % | | | | |

Дүүргийн эдийн засгийн үзүүлэлт

**Дүүргийн төсөв:**

Дүүргийн төсвийн нийт орлого 2023 онд 6344425.6 мян.төг болж бүрдсэнээс. Төсвийн нийт орлого 952154.0 мян.төгрөгөөр татварын орлого, 210000.0 мян.төгрөгөөр татварын бус орлого, 301010.7 мян.төгрөгөөр ОНХС-ийн шилжүүлэг, 4881260.9 мян.төгрөгөөр нийслэлийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээр бүрджээ. Энэ нь өмнөх оны(2022) нийт орлогоос 12.7% -иар өссөн үзүүлэлт юм.

Аж үйлдвэр

Дүүргийн нутаг дэвсгэрт төмөрлөгийн 3, хөнгөн цагааны 1, керамзитын 1, бусад чиглэлийн 3 үйлдвэр улирлын чанартай үйл ажиллагаа эрхэлж байна. Уг үйлдвэрүүд ажилласнаар жилд 135 хүнийг ажлын байраар хангаж, дүүргийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байна.

**Мах боловсруулах үйлдвэр.** Багахангай дүүргийн Мах боловсруулах үйлдвэр нь Финлянд улсын хөрөнгө оруулалтаар 1994 онд баригдсан.

Жилд 20000 бод, 20000 бог, 6,5 мянган гахай нядлах нядалгааны цех, хоногт 300 тонн чанамал хиам, 600 тн бүтэн утлагатай хиам үйлдвэрлэх хиаман цех, хоногт ээлжиндээ 1,5 тн мах шуллагааны цех, 500 тн-ын хөлдөөх зоорь, өлөн боловсруулах, арьсанд анхан шатны боловсруулалт хийх цехүүдтэй.

Хөдөө аж ахуй.

**Газар тариалан.** Дүүргийн хэмжээгээр нийт 150 га талбайд үр тариа, мөн 2.1 га талбайд төмс, 80 га талбайд тэжээлийн ургамал, 3.3 га талбайд хүнсний ногоо буюу нийтдээ 235.4 га талбайд тариалалт хийж байна. Үүний 231.47 га талбай нь 1-р хорооны нутагт, үлдсэн багахан хувь нь 2-р хорооны нутагт байна.

**Мал аж ахуй.** Дүүргийн хэмжээнд нийт 28.41 мян.толгой мал байна. Үүнээс:




*График 3. Багахангай дүүргийн мал аж ахуй /малын төрөл, эзлэх хувиар/*

Ус суваг ашиглалтын товчоо

Хэрэглэгчдийг унд ахуйн стандартын шаардлагад нийцсэн усаар тасралтгүй хангах экологийн тэнцвэрийг хадгалах шалгуурт тохирсон усыг байгальд нийлүүлэх эрхэм зорилттой Ус суваг ашиглалтын товчоо нь хоногт 2760 м3 ус олзворлох хүчин чадалтай 4 худаг, 3264 м3 бохир ус татан зайлуулах хүчин чадалтай бохирын станц, 2880 м3 ус хэрэглэгчид түгээх хүчин чадалтай 2 станц, 500м3 багтаамж бүхий төмөр бетонон усан сан, 3790 м3 цэвэр усны 1608 м бохир усны шугамыг хариуцан ажилладаг. 404,0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 10,9 сая эргэлтийн хөрөнгөтэй.



*Зураг 2. Багахангай дүүргийн ус суваг ашиглалтын товчоо*

Эрүүл мэндийн үйлчилгээ

Эмнэлгийн ажилтны ёс зүйг эрхэмлэн дээдэлж эмчлэн сэргийлэх тусламж үйлчилгээг боловсон шуурхай соёлтой чанартай хүртээмжтэй хүргэх чиг бүхий 15 ортой Хүн эмнэлэг, Төмөр замын их эмчийн салбар нь эрүүл мэндийн салбарын хөгжлийг хүн амын эрүүл мэндийг дэмжин хамгаалах 2 талт үйл ажиллагаанд чиглүүлэн халдварт ба халдварт бус өвчлөл, эхийн эндэгдэл, шүд амны хөндийн өвчлөлийг бууруулах тэдгээрээс урьдчилан сэргийлэх эмчилгээ, оношлогооны чанарыг сайжруулах, эрүүл хүн амыг дэмжих, иргэдийн оролцоо хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Жилд 11200 үзлэгээс 5787 урьдчилан сэргийлэх үзлэг хийж гэрийн эргэлтээр 1246 хүн хамруулж, 543 хүн хэвтэн эмчлүүлж байна.




*Зураг 3. Багахангай дүүргийн эрүүл мэндийн төв*

Соёлын ордон

Соёлын талаар явуулж буй бодплого шийдвэрийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх иргэдэд соёл урлагаар үйлчлэх соёлын ордон нь иргэдийн эрэлт хэрэгцээ хүсэл сонирхол насны онцлогт тохируулан соёл хүмүүжил олгох, авьяас билэгийг нээн илрүүлэх, хөгжүүлэх зорилго тавин үйл ажиллагаагаа явуулж ирлээ. Соёлын ордоны дэргэд насны ангилалаар дуу, хөгжим, бүжиг, морин хуурын дугуйлан хичээллэж ардын ёс заншлын танхим, бичил номын сантай болж Соёлын цаг нэвтрүүлэг явуулж хэвшүүллээ.



*Зураг 4. Багахангай дүүргийн соёлын ордон*

Илч-Орд НӨҮГазар

Илч-Орд Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь 18,0 мян.ам метр албан үйлчилгээний газар 6,0 мян.ам метр 5 давхар 4 орон сууцны талбайг дулаан дамжуулан 0219 м2 600 м урт төв 084 мм-тэй салбар шугамыг ашиглаж, Герман технилогоор үйлдвэрлэгдсэн КВМ-1, 1,86 маркын 2 зуухаар дүүргийн халаалтын системийг найдвартай ажиллуулж хэрэглэгчдийг дулаанаар хангаж 8 тн-ын даацын Донг-фенг ниссан дизель маркийн автомашинуудаар парк шинэчлэл хийгдсэн. Мөн тус газар нь хот тохижилтын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж дүүргийн өнгө үзэмж тохижилтыг сайжруулахад анхааран ажиллаж байна.

Эрчим хүч

Дүүрэг нь улсын төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон 1600 квт хүчин чадал бүхий 1 дэд станц, цахилгаан дамжуулах 35 кв-ын 200 км урт цахилгаан дамжуулах шугамаар 211,3 сая төгрөгний борлуулалтын орлого оруулдаг. Жилд 47 аж ахуйн нэгжид 2,9 сая квт цахилгаан, 400 гаруй айл өрхөд 0,4 сая.квт цаг эрчим хүчийг үйлдвэрлэн түгээлээ. Төв аймгийн Баянцагаан, Баян сумдыг 35 квт-ын цахилгаан дамжуулах шугамаар тэжээн хариуцдаг, Өндөртолгойн эрчим хүчний хэсэг, Төмөр замын Хайрхан-Агуйт, Булагтай, Багануурын өртөө зөрлөг, тэнд оршин суугчид дүүргийн 2-р хорооны иргэдийг цахилгаан эрчим хүч, ундны цэвэр усаар хангадаг 0,4, 6,10,35 квт-ын 350 м-ийн цахилгаан дамжуулах агаарын шугам 0,4 6,10 кв-ын кабель шугам 6,10 квт-ын хаалттай хуваарилах 3 байгууламж 6,10 кв-ын бүрдмэл хуваарилах 37 байгууламж усны 4 насост станц 11 гүний шахуургат худгийг ажиллуулан хэрэгчдийг эрчим хүчээр найдвартай хангаж байна.

Багахангай өртөө

Багахангай өртөө нь Улаанбаатар-Замын үүд-Багануурын чиглэлд хоногт 22-24 галт тэрэг өнгөрч жилд 15-16,4 сая тонн ачааг тээвэрлэж 4,5-5,2 сая тонн транзит ачааг дэмжин өнгөрүүлж дунджаар 2,5 сая зорчигч дайран өнгөрдөг 2-р зэргийн өртөө юм. Замын 17-р хэсэг нь Багахангай-Багануурын болон гол замын 20 гаруй км зам, 10 гаруй замын арчилгаа засварыг хийж техник үзлэгийн газар хоногт 120 вагонд засвар үйлчилгээ хийн галт

тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.




*Зураг 5. Багахангай өртөө*

Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн тасаг

Иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэрэг гаралтыг бууруулах, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх аврах хор уршгийг арилгах төрийн тусгай үүрэг гүйцэтгэдэг чиг үүрэг бүхий онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн тасгийн бие бүрэлдэхүүн төр иргэдийнхээ өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж өгөгдсөн үүрэг тавигдсан зорилтыг цаг тухайд нь шударгаар биелүүлж ирсэн түүхэн уламжлалтай.

Мэдээллийн сүлжээ

Дүүрэгт үүрэн телефоны 4 опеторын сүлжээг ашигладаг бөгөөд 2006 оноос дүүрэгт орчин үеийн мэдээллийн сүлжээ бүтэц бий болсоноор МТЗ-ын холбооны Рейлкомын шилэн кабелиар аж ахуйн нэгж байгууллага, иргэд үйлчилгээ авч ирсэн бөгөөд өнөөгийн байдлаар шилэн кабелаар өндөр хурдны интернет ашиглах техникийн нөхцөл боломж бүрдээд байна.

Дүүргийн 1-р хороонд кабелийн телевизээр үндэсний 10, гадаадын 15, 2-р хорооны оршин суугчид Төмөр замын кабелийн телевизээр үндэсний 15 суваг, гэр хороололын оршин суугчид үндэсний телевизийн 6 сувгийг нэгэн зэрэг хүлээн авч үзэж байна.

Тус дүүрэг нь Улаанбаатар хоттой 107 км төмөр замаар, 90 км хатуу хучилттай хар замаар холбогдсон бөгөөд Улаанбаатар-Замын-Үүд, Улаанбаатар-Багануур чиглэлийн төмөр замын зангилаа дээр болон Улаанбаатар-Замын-Үүдийн босоо тэнхлэгийн хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг хэсэг дээр оршдог. Монгол Улсын Их Хурлын 2003 оны 54-р тогтоолоор нийслэлийн Багахангай дүүрэгт "Үйлдвэрлэл технилогийн парк" байгуулах зориулалт, хэлбэр чиглэлийг тодорхойлж өгсөн нь тус дүүргийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон томоохон арга хэмжээ боллоо.Тус дүүрэг нь 1992 онд байгуулагдсан бөгөөд одоо засаг захиргааны 2 хороотой, 1045 өрхийн 3724 хүн амтай, 12971 толгой малтай.

## 1.2 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

### *1.2.1 Байгаль орчны нөлөөллийн тодорхойлолт*

Хоѐрдогч түүхий эд ашиглаж нэмүү өртөг бий болгох энэхүү төсөл нь уул уурхай, олборлох салбартай харьцуулахад байгаль орчинд нөлөөлөх байдлаараа сөрөг нөлөө дунд, нөлөөллийн эрчим сул гэж тогтоогдсон.

**Хүснэгт 6. Аюултай хог хаягдал боловсруулах үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн тодорхойлолт**

| № | Төслийн хүрээний сөрөг нөлөөллийн асуудал | Сөрөг нөлөөллийн хэмжээст параметрүүд | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Цэвэр усны нөөцийг газрын доорхи гүний уснаас хангана. | • Унд ахуйн хаягдал ус 216.0м$^3$/жил | |
| 2 | Усыг эргэлтээр ашиглахгүй, байгальд бохир ус хаяна. | • Бохирдуулах бодисын хэмжээ 324 кг | |
| 3 | Төслийн талбайн хөрсний бохирдол | Хөрсөнд аюултай химийн бодис нэвчиж болзошгүй бөгөөд нөлөөлөл төслийн талбайгаас гадагшлахгүй. | |
| 4 | Төслийн талбайн ургамлан нөмрөгийн тахлагдал | Барилга байгууламж бүхий орон зайн хэмжээгээр ургамлан нөмрөг устсан. | Сул орон зайд ногоон бүс тохижуулах боломжтой. |

### *1.2.2 Үйлдвэрийн нийгмийн ач холбогдол.*

Тус үйлдвэрийн бүтээгдэхүүн "Монгол эко" дизель түлш нь УБД0000302 дугаар бүхий чанарын тохирлын гэрчилгээ авсан буюу евро-4 стандартын шаардлага хангасан /Агуулагдах хүхрийн хэмжээгээрээ тодорхойлогддог- тус үйлдвэрийн дизель түлш нь стандартаас заасан хэмжээнээс бага хүхрийн агууламжтай тул байгаль орчинд хор багатай/

Өнөөдрийг хүртэл тус үйлдвэр нийт 5 000 000 литр гаруй тонн хөдөлгүүрийн ашигласан тосыг дахин боловсруулж байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулсан байна.

# 2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цар хүрээ

